

Завхан аймаг дахь Төрийн  
аудитын газар



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн  
нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд  
хийсэн санхүүгийн тайлангийн аудит

АУДИТЫН КОД: ЗАА-2021/1/СТА-ТЕЗ



Улиастай сум  
2021 он

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд  
тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас:99993365 Цахим хаяг: [bat-undraad@audit.gov.mn](mailto:bat-undraad@audit.gov.mn)

Аудитын менежер: Г.Хашцэцэг

Утас: 9901649 Цахим хаяг: [khashtsetsegg@audit.gov.mn](mailto:khashtsetsegg@audit.gov.mn)

Ахлах аудитор: Д.Оюунжаргал

Утас:99460422 Цахим хаяг: [oyunjargald@audit.gov.mn](mailto:oyunjargald@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.  
Цахим хаяг: [www.audit.mn](http://www.audit.mn)

## 1. Агуулга

1.	Аудитын гэрчилгээ.....	3
2.	Аудитын тайлан.....	5
2.1.	Оршил.....	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	5
	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8.1	Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө.....	8
2.8.2	Авлага.....	9
2.8.3	Урьдчилгаа.....	10
2.8.5	Бараа материал.....	11
2.8.6	Үндсэн хөрөнгө.....	12
2.8.8	Өр төлбөр.....	13
2.8.9	Засгийн газрын хувь оролцоо.....	13
2.9.1	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	14
2.10.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	18
2.11.	Шилэн дансны мэдээлэл.....	18
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	18
2.13.	Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	19
3.	Менежментийн захидал.....	19
4.	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	20
4.1	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	20
4.2	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	21
4.3	Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	23
4.4	Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	26
5.	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	27
5.1	Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	27
5.2	Аудитын зөвлөмж.....	30
5.3	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	31

**Товчилсон үгийн жагсаалт**

<b>АДБОУС</b>	<b>Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт</b>
<b>АОУС</b>	Аудитын Олон Улсын Стандарт
<b>УСНББОУС</b>	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
<b>ТТЗ</b>	Төсвийн төвлөрүүлэн захирагч
<b>ТШЗ</b>	Төсвийн шууд захирагч
<b>ОНХС</b>	Орон нутгийн хөгжлийн сан
<b>СХС</b>	Сум хөгжүүлэх сан
<b>ЗДТГ</b>	Засаг даргын тамгын газар
<b>ЕБС</b>	Ерөнхий боловсролын сургууль
<b>ЭМТ</b>	Эрүүл мэндийн төв

## 1. Аудитын гэрчилгээ



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81000 Улиастай, Завхан аймаг  
Утас/Факс: 7046-36-12

2021.04.19 № 510

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ  
ДАРГА Д.ТҮВШИНЖАРГАЛ ТАНАА

### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь санхүүгийн болон аудиторын тайланд тусгагдсанаас бусад санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулах бөгөөд аудитаар бусад мэдээлэлтэй холбоотой буруу илэрхийлэл байхгүй байна.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

013021671


**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

## **2. Аудитын тайлан**

---

### **2.1. Оршил**

Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Завхан аймгийн Засаг дарга Д.Түвшинжаргал танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

#### **Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасны дагуу Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, НББОУС, СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, НББОУС, СТОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2021 оны 04 дүгээр сарын 05-аас 2021 оны 04 дүгээр сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, ахлах аудитор Д.Оюунжаргал, аудитор Б.Жалбаа нар гүйцэтгэв.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

#### **2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь Аймгийн Засаг даргын тамгын газар нь оновчтой бодлого зохицуулалтаар хангах замаар аймгийнхаа хөгжилд дэмжлэг үзүүлэх нь эрхэм зорилго юм гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

- 1 Төсвийн болон худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангаж, бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааг сайжруулан, мэдээлэл судалгааны чанар болон хөрөнгийн өгөөжийг нэмэгдүүлнэ.
- 2 "Сайн малчин", "Хүнсний ногоо", "Завханы улаан хальст саримс" дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулна. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд газар эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэх;
- 3 Газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр Байгаль орчны тэнцвэрт байдлыг хангаж, байгалийн нөөц баялгийг зохистой ашиглан, ногоон орчин бүрдүүлнэ.
- 4 Хүнс, үйлдвэрлэл, үйлчилгээ
- 5 Байгаль орчны тэнцвэрт байдлыг хангаж, байгалийн нөөц баялгийг зохистой ашиглан, ногоон орчин бүрдүүлнэ.
- 6 Барилгын гүйцэтгэлийг чанартай зохион байгуулна.
- 7 Шинэ барилга
- 8 Барилгын их засвар.
- 9 Улсын болон орон нутгийн чанартай авто замын барилга, засварын гүйцэтгэлийг чанартай зохион байгуулна.
- 10 "Сайн эмч" хөтөлбөрийн хүрээнд эрүүл мэндийн удирдлагын манлайллыг дээшлүүлэн, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай хүргэж, дэвшилтэт технологи нэвтрүүлнэ
- 11 "Сайн багш" дэд хөтөлбөрийн хүрээнд багшийн мэргэжлийн үнэлэмж, ур чадварыг нэмэгдүүлэн, суралцагчийн мэдлэг, чадварыг хөгжүүлж, бүх шатны сургалтын амжилт, чанарыг дээшлүүлэн, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 12 Хүн амын нийтийн биеийн тамир, спортоор хичээллэх орчинг бүрдүүлж, аймаг, бүс, улсын спортын уралдаан тэмцээнд оролцох оролцоог нэмэгдүүлнэ.
- 13 Соёл урлагийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, түүх соёлын өвийг хадгалах, хамгаалах, сурталчлах ажлыг сайжруулна.
- 14 Хүүхэд, залуучуудын манлайлал, хөгжил оролцоог нэмэгдүүлэн, хүүхэд бүр монгол ёс заншил, өв уламжлал, байгаль дэлхийгээ хайрласан, эх оронч үзэлтэй болж төлөвшинө.
- 15 Иргэдэд чиглэсэн төрийн бодлогыг хэрэгжүүлэх, тэдний сайн сайхны төлөө төрөөс үзүүлж буй хөдөлмөр, халамжийн үйлчилгээг зорилтот бүлгийн хүн амд хүргэж, эрхийг хангана.
- 16 Төрийн албан хаагчийн ажлын хариуцлага, мэргэжлийн ур чадвар, манлайллыг дээшлүүлэх, ил тод, хариуцлагатай төрийн албыг бэхжүүлэн, төрийн байгууллагаас иргэдэд үзүүлэх үйлчилгээг шуурхай хүргэнэ.
- 17 Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, мэргэжлийн анги, иргэдийг сургаж дадлагажуулах, бэлэн байдлыг хангана.
- 18 Хүний эрхийг хангаж, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлнэ.

19 Цэргийн алба хаах насны иргэдэд эх оронч үзэл, хүмүүжлийг төлөвшүүлэх, иргэн цэргийн харилцааг бэхжүүлэн, иргэдэд эх орноо хамгаалахад оролцох, цэргийн бэлтгэл эзэмшүүлэх замаар улс орны батлан хамгаалах нөөц, чадавхыг нэмэгдүүлэх гэсэн дэд зорилтуудын хүрээнд 156 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн 153 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэн Аймгийн ИТХ-ын Хурлын хуралдаанаар 98.2 хувийн биелэлтэй дүгнэгдсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан зүйл ажиглагдаагүй болно.

## **2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журамд нийцэж байна.

Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 2 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр мөнгөн гүйлгээний тайлангийн нийт орлогыг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг ТЕЗ-ийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн мөнгөн гүйлгээний тайлангийн нийт хөрөнгийн дүнгээс 2 хувь буюу 2,724.5 сая төгрөгөөр тогтоов.

Нийт хөрөнгийг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь аудитын явцад илрүүлсэн эрсдэлтэй асуудалд үнэлгээтэй холбоотой юм.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

## **2.8 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга, аудитын дүн**

**Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

**2.8.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө**

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 4,777.3 сая, эцсийн үлдэгдэл 6,628.0 сая төгрөг болж 1,850,6 төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+/ бууралт/-/
<b>Касс байгаа бэлэн мөнгө</b>	0.8	10.7	9.90
<b>Дүн</b>	<b>0.8</b>	<b>10.7</b>	<b>9.90</b>
Үүнээс: байгууллагын төрлөөр			-
Төсөвт байгууллага	0.8	10.7	9.90
Төсөл / сан			-
Төрийн сан			-
ТӨҮГ болон ОНӨААТҮГ			-
<b>Дүн</b>	<b>0.8</b>	<b>10.7</b>	<b>9.90</b>

*Эх сурвалж:* Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

**Төрийн сангийн мөнгөн хөрөнгө**

Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 1,151.4 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 1,944.1 сая төгрөг болж 792,8 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №2. Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+/ бууралт/-/
<b>Банканд байгаа мөнгөн хөрөнгө</b>			-
Төгрөг			-
Төрийн сан	4,559.3	6,252.5	1,693.2
Арилжааны банк	29.5	36.1	6.6
Нэмэлт санхүүжилтийн харилцах	186.7	328.6	141.9
Нэмэлт санхүүжилтийн арилжааны банк	1.0		(1.0)
Гадаад валют			-
Монгол банк			-
Зам яваа хөрөнгө			-
<b>Дүн</b>	<b>4,776.5</b>	<b>6,617.2</b>	1,840.7

*Эх сурвалж:* Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант оны мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 6.628.0 төгрөг байна. Үүнээс 1,489.4 сая төгрөг төсөвт байгууллагын, 1,065.7 сая төгрөг нь төсөл, сангийн, 4,062.5 сая төгрөг нь төрийн сангийн, 10.3 сая төгрөг нь төрийн болон орон нутгийн өмчит байгууллагын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл байна.

Төрийн сангийн эхний үлдэгдлээс тайлант онд 3,910.1 сая төгрөгийн зарцуулах эрх нээгдсэнээс 914,7 сая төгрөгийг орон нутгийн төсвийн зарлагыг санхүүжүүлэхэд, 2,276.1 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд, СХС-ийн санхүүжилтэд 719.3 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

*Аудитын илрүүлэлт: Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын мөнгөн хөрөнгийн данстай холбоотой илэрсэн алдаа, зөрчлүүдээс дурдвал:*

- ✓ Цагаанчулуут сум Төрийн банкны 171900002201 тоот дансанд сумын төсөвт байгууллагуудын хэмнэсэн зардлаас Аймгийн засаг даргын 2020-12-07-ний өдрийн 1/1285 тоот, сумын Засаг даргын 2020-12-27-ны өдрийн А/97 тоот захирамжуудаар “Гамшгийн хамгаалах сан” бүрдүүлэн байршуулсан 15,672.7 мянган төгрөгийг оны эцэст татан төвлөрүүлээгүй байсан алдааг илрүүлэн холбогдох албан тушаалтанд харууллага тооцуулах албан шаардлага хүргүүлэн ажилалаа.

**Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

- ✓ *Аймгийн орон нутгийг судлах музей: Ажилчдын нэрийн дансаар 2733.0 мянган төгрөгийг бэлнээр авч аж ахуйн материал худалдан авсан алдааг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлээ*
- ✓ *Дөрвөлжин сум оны эцэст орон нутгийн төсөвт байгууллагуудын үйл ажиллагааны зардлын гүйлгээг төрийн сангийн гүйлгээ хаахаас өмнө хийгээгүй, төсөвт байгууллагуудад өр төлбөр үүсгэсэн Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 39 дүгээр зүйлийн 39.4.2 “өр, авлага үүсгэхгүй байх”, 41 дүгээр зүйлийн 41.2.3 “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” Засгийн газрын 2014 оны “Санхүүгийн албаны зохион байгуулалт, чиг үүрэг, орон тооны жишиг норматив батлах” тухай 326 дугаар тогтоолын 1.3. Нягтлан бодогчид, 1.3.1 “төсвийн орлого, зарлагын өдөр тутмын гүйлгээг хийх, бүртгэх, тайлагнах” гэсэн заалтуудыг зөрчсөн, санхүүгийн алба, нягтлан бодогчдын ажлын хариуцлагагүй байдал, ажлын уялдаа холбоо хангалтгүй байгаатай холбоотой гарсан зөрчлийг илрүүлэн санхүү хариуцсан алба хаагчдад хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлээ.*
- ✓ *Түдэвтэй сумын сургууль: Няравын дансаар дамжуулан зарцуулалт хийгдсэн мөнгөн хөрөнгийн зарцуулагдаагүй үлдэгдэл 0,8 сая төгрөгийг бүртгэлд тусгаагүй байсан алдааг санхүүгийн тайланд залруулан авлагаар тусгууллаа.*
- ✓ *Дөрвөлжин сумын сургууль: Ажлаас халагдсан жолоочид шүүхийн шийдвэрийн дагуу цалин, шимтгэлд 7,2 ася төгрөгийг төлсөн алдааг илрүүлэн зөвлөмж өгсөн, цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлын хэмнэл 7,5 сая төгрөгийг нийгмийн даатгалын шимтгэлд, 3.0 сая төгрөгийг халаалтын Ган Доной ХХК-руу тус тус шилжүүлэн авлага үүсэн зөрчил төлбөрийн акт тогтоосон.*

## 2.8.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 6,060.9 сая, эцсийн үлдэгдэл 6,061.5 сая төгрөг болж, 0.6 сая төгрөгөөр өссөн байна.

<i>Хүснэгт №3. Авлагын үлдэгдэл /сая төгрөг/</i>			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+ / бууралт/-/
<b>Авлага</b>	<b>306.1</b>	<b>323.0</b>	16.9
Ажиллагчидтай холбогдсон авлага	46.5	59.0	12.5
Төлбөртэй үйлчилгээний авлага	156.7	153.8	(2.9)
Татаас, санхүүжилтийн авлага	8.4	-	(8.4)
Дансны авлага /ТӨҮГ/	94.4	106.1	11.7
Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	-	4.1	4.1
<b>Бусад авлага</b>	<b>5,754.8</b>	<b>5,738.4</b>	<b>(16.4)</b>
Байгууллагаас авах авлага	150.1	143.1	(7.0)
Хувь хүмүүсээс авах авлага	5,604.7	5,595.3	(9.4)
<b>Урьдчилж гарсан зардал</b>	<b>72.4</b>	<b>56.6</b>	<b>(15.8)</b>
Үндсэн хөрөнгө бэлгэх урьдчилгаа	-	0.5	0.5
Цалингийн урьдчилгаа	-	0.4	0.4
<b>Дүн</b>	<b>6,060.9</b>	<b>6,061.4</b>	<b>0.5</b>
Үүнээс байгууллагын төрлөөр			-
Төсөвт байгууллага	5,755.8	5,715.0	(40.8)
Төсөл сан	41.5	41.5	-
Төрийнсан	153.7	153.7	-
ТӨҮГ болон ОНӨҮГ	109.9	151.3	41.4
<b>Дүн</b>	<b>6,060.9</b>	<b>6,061.5</b>	<b>0.6</b>

*Эх сурвалж Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Авлагын эцсийн үлдэгдэл 6,061.5 сая төгрөгийн 5,505.3 сая төгрөг нь СХС-гийн зээлийн авлагын үлдэгдэл байна.

СХС-ийн авлагын 75,4 хувь буюу 4,573.0 сая төгрөг нь 4-өөс дээш жилийн хугацаатай авлага байна.

**Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Насжилт өндөртэй авлагыг барагдуулах бодит ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулж ажиллахад 4-өөс дээш жилийн хугацаа хэтрэлттэй авлагын 40%-ийг барагдуулна гэж тооцвол 1,829.2 сая төгрөгийн, төсөвт байгууллагуудын авлагыг бүрэн барагдуулбал 556.2 сая төгрөгийн үр өгөөж бий болох боломж байна гэж үзлээ.

*Аудитын илрүүлэлт: Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын авлагын данстай холбоотой илэрсэн нийтлэг алдаа, зөрчлүүдээс дурдвал:*

1. *Тайлант оны эцэст хэмнэгдсэн зардлыг төсөвт буцаан төвлөрүүлэлгүй, нийгмийн даатгалын шимтгэлд шилжүүлж авлага үүсгэсэн*
  - ✓ *Орон нутгийн өмчийн газар: 1,7 сая төгрөгийн,*
  - ✓ *Цэцэн-уул сумын Соёлын төв: 1,4 сая төгрөгийн,*
  - ✓ *Улиастай сумын ерөнхий боловсролын Чандмань-Эрдэнэ лаборатори сургууль: 0,9 сая төгрөгийн алдаа тус бүрт төлбөрийн акт тогтоолоо.*
2. *Түлш, халаалт, шатахууны зардлын хэмнэлтийг бэлтгэн нийлүүлэгч компанид шилжүүлэн авлага үүсгэсэн*
  - ✓ *Тосонцэнгэл сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургууль: 7,8 сая төгрөгийн алдааг илрүүлэн төлбөрийн акт тогтоолоо*
  - ✓ *Улиастай сумын ИТХурал: 0,4 сая төгрөгийн алдааг бараа материалын үлэгдлээр залруулан тайланд тусгалаа.*
3. *Бэлтгэн нийлүүлэгчээс буцаасан барааг авлагаар бүртгээгүй*
  - ✓ *Улиастай 1-р цэцэрлэг : 9,0 сая төгрөгийн бараа матзриалыг бүртгэлд тусгаагүй хүлээн аваагүй зөрчлийг илрүүлэн зөвлөмж өглөө.*
  - ✓ *Шилүүстэй сумын дунд сургууль: барагдсан авлагыг данс бүртгэлээс хасаагүй 1,0 сая төгрөгийн алдааг залрууллаа.*
4. *Цаингийн урьдчилгаа болон бусад авлагыг бүртгэл тусгаагүй*
  - ✓ *Асгат сумын ЕБС: НДШ-ийн баталгаажсан 0,5 сая төгрөгийн авлагыг тайланд тусгаагүй алдаау аудитын явцад залруулж, цалингийн урьдчилгаа олгоод бүртгээгүй, суутган тооцоогүй 2.2 сая төгрөгийн алдаа, зөрчилд төлбөрийн акт тогтоосон*
5. *Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгдсэн тайланд аймаг, сумдын төсөвт байгууллагуудын ихэнх нь 13.1-520.2 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.*

*Эх сурвалж Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

### 2.8.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 72,4 сая, эцсийн үлдэгдэл 57,5 сая төгрөг болж 14.9 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт №4. Урьдчилгаа дансны үлдэгдэл /сая төгрөг/*

<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>72.4</b>	<b>57.5</b>	<b>(14.9)</b>
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон			
Төсөвт байгууллага			
Тусгай зориулалтын сан			
Төрийн өмчийн үйлдвэр, аж ахуйн газар			
Хувийн хэвшлийн үйлдвэр, аж ахуйн газар			
Урьдчилж гарсан зардал	72.4	56.6	(15.8)
<b>Урьдчилгаа тооцоо</b>	<b>-</b>	<b>0.9</b>	<b>0.9</b>
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа		0.5	0.5
Цалингийн урьдчилгаа		0.4	0.4

*Эх сурвалж Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Энэ бууралт нь байгаль хамгаалах нөхөн сэргээлт хийгдсэн ажилтай холбоотой гарсан зардлын гүйцэтгэл 5,4 сая төгрөг, “Тосон-Очирт хайрхан” ОНӨҮГ-ын 2020 оны 6 сард

**Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

өмнөх санхүүгийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийн дагуу хийгдсэн 9,5 сая төгрөгийн залруулгын дүнгээр буурчээ.

**Аудитын илрүүлэлт:**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгдсэн тайлан дахь байгаль хамгаалах нөхөн сэргээлт урьдчилгааны үлдэгдэл 57,6 сая төгрөг нь он дамжин барагдаагүй байгаа тул аудитаар зөвлөмж өглөө

**2.8.5 БАРАА МАТЕРИАЛ**

Бараа материалын эхний үлдэгдэл 6, 397.3 сая, эцсийн үлдэгдэл 7,248.6 сая төгрөг болж, 851,3 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №5. Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/*

<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>6,397.30</b>	<b>7,248.60</b>	851.30
<b>Түүхий эд материал</b>	<b>776.40</b>	<b>1,130.80</b>	354.40
Тусгай зориулалттай материал	676.90	905.70	228.80
Эм боох материал	99.50	225.10	125.60
Дуусаагүй үйлдвэрлэл			-
Бэлэн бүтээгдэхүүн	26.90	64.90	38.00
<b>Хангамжийн материал</b>	<b>5,371.20</b>	<b>5,798.10</b>	426.90
Бичиг хэргийн материал	255.00	282.80	27.80
Аж ахуйн материал	1,787.30	1,953.10	165.80
Сэлбэг хэрэгсэл	29.30	46.30	17.00
Түлш, шатах тослох материал	400.20	311.80	(88.40)
Барилгын засварын материал	2,025.00	167.10	(1,857.90)
Хүнсний материал	589.50	464.80	(124.70)
Бусад хангамжийн материал	2,107.30	2,572.20	464.90
Биологийн хөрөнгө			-
Мал амьтад	222.80	254.80	32.00

*Эх сурвалж: Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Бараа материалын үлдэгдэлд тайлант онд худалдан авсан 7,293.3 сая төгрөгийн, хандив тусламжаар 810,8 сая төгрөгийн, шилжүүлэн авсан 67,1 сая төгрөгийн, бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлэн авсан 14,7 сая төгрөгийн, бусад эх үүсвэрээр 94,1 сая төгрөгийн, нийт 8,280.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

**Аудитын илрүүлэлт:** Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгээгдсэн байгууллагуудын бараа материалын данстай холбоотой илэрсэн алдаа, зөрчлүүдээс дурдвал:

1. Бараа материалын тооллогыг шаардлагын хэмжээнд хийдэггүй
  - ✓ Улиастай сумын 1 дүгээр цэцэрлэг- аудитын явцад хүнсний материалын үлдэгдлийг тоолоход 4,2 сая төгрөгийн,
  - ✓ Улиастай Жавхлант цогцолбор сургууль- мөн 2,5 сая төгрөгийн бараа материалын дутагдал гаргасанд тус тус төлбөрийн акт тогтоолоо.
  
2. Няравын тайланг шалгаж хүлээн авдаггүй, шатах тослох материалын тайланг үнэн зөв гаргадаггүй
  - Шилүүстэй, Цэцэн-уул сумдын дунд сургууль
  - Завханмандал сумын ЗДТГ:
    1. Тайлант хугацааны 6,5 сая төгрөгийн шатахууны их хэмжээний үлдэгдэл байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1."Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"; заалттай нийцэхгүй, Энэ нь Иж бүрэн байх, Эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа алдаа, зөрчлийг илрүүлэн албан шаардлага хүргүүлсэн .
    2. Балансад бүртгэлтэй байгаа малаас зах зээлд борлуулсан гэх 32 тооны 3,8 сая төгрөгийн ямааг бүртгэлээс хасч худалдан борлуулсан орлогыг улсын төсөвт төвлөрүүлээгүй алдаа, зөрчлийг илрүүлэн төлбарийн акт тогтоолоо.

**Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

3. Тайлант онд үндсэн хөрөнгийн шинж чанартай 9,2 сая төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн алдаанд залруулан ажиллах зөвлөмж хүргүүлээ.

- Гэр бүл хүүхэд залуучуудын төв:
  1. Худалдан авч зарцуулсан 6,4 сая төгрөгийн шатахууныг тооцооны дансаар дамжуулаагүй, уг шатахуунаас 2,7 сая төгрөгийн шатахууны тооцоог журмын дагуу тооцоогүй тул 3 заалт бүхий зөвлөмж хүргүүлээ
  2. Дутагдуулсан бараа материалын 2,2 сая төгрөгт төлбөрийн акт тогтоон санхүүгийн тайланг хязгаарласан.
- Түдэвтэй сумын сургууль: БШУ-ны сайдын А/162 тушаалын дагуу 1,5 сая төгрөгийн хоол хүнсний материалыг зорилтот бүлгийн хүүхдүүдэд үнэ төлбөргүй тарааж өгсөн ажил гүйлгээг үр дүнгийн тайланд үйл ажиллагааны зардлаар бүртгэсэн ажил гүйлгээг бараа материалын тайланд,

Эрх бүхий байгууллагын шийдвэрээр худалдан авсан үндсэн хөрөнгийн шинжтэй 2,4 сая төгрөгийн камер дагалдах хэрэгслэлийг бараа материалаар орлого авч тайлагнасан алдааг үндсэн хөрөнгөнд бүртгүүлэн залруулаа.

Халаалтын зардлын төлбөрийг НӨАТ төлөгч бус этгээдэд НӨАТ-н 10 хувь 10,0 сая төгрөгийг нэмж шилжүүлсэн нь алдааг авлага үүсгэн тайланд залруулсан

Халаалтын хөлсний тооцооны бүртгэл хөтлөлтийг бараа материалын дансаар дамжуулан хийж байгаа нь алдааг илрүүлэн зөвлөмж өглөө.

### 2.8.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө нь хуримтлагдсан элэгдлийг хассан цэвэр дүнгээр эхний үлдэгдэл 149,930.2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 164,412.8 сая төгрөг болж, 14,482.6 сая төгрөгөөр өссөн байна.

Биет хөрөнгө	Хүснэгт №6. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/		
	149,930.20	164,412.80	14,482.60
Барилга байгууламж орон сууц	103,088.70	114,843.30	11,754.60
Авто-тээврийн хэрэгсэл	6,904.90	7,358.50	453.60
Машин тоног төхөөмөмж	18,497.40	19,890.60	1,393.20
Тавилга, аж ахуйн эд хогшил	6,550.40	6,887.60	337.20
Зам, гүүрийн байгууламж	9.10	9.10	-
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	1,229.00	1,236.90	7.90
Бусад үндсэн хөрөнгө	6,355.10	6,417.00	61.90
Ном	1,476.30	1,582.60	106.30
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>5,819.20</b>	<b>6,186.90</b>	<b>367.70</b>
Програм хангамж	152.30	333.80	181.50
Бусад биет бус хөрөнгө	5,666.90	5,802.10	135.20
Бусад үндсэн хөрөнгө		51.00	51.00

Эх сурвалж: Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,

Тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 882,3 сая төгрөгийн, улс орон нутгийн хөрөнгө оруулалт, үнэ төлбөргүй хандив, тусламжаар 9,135.5 сая төгрөгийн, балансаас баланст шилжүүлэн авсан 115,7 сая төгрөгийн, шилжүүлэн авсан 20.2 сая төгрөгийн, бусад эх үүсвэрээр нэмэгдсэн 6,743.6 сая төгрөгийн, үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлээр 89,2 сая төгрөгийн нийт 16,986.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэн, 2,504.0 сая төгрөгийн хөрөнгийг акталсан, 326.6 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн, 209.1 сая төгрөгийн хөрөнгийн дахин үнэлгээ хорогдож, нийт 2,504.0 сая төгрөгийн хөрөнгө данснаас хасагдсан байна.

*Аудитын илрүүлэлт: Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгээгдсэн байгууллагуудын үндсэн хөрөнгийн данстай холбоотой илэрсэн алдаа, зөрчлүүдээс дурдвал:*

1. Аймгийн ИТХ-ын шийдвэргүй үндсэн хөрөнгө бэлтгэсэн

**Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

- Шилүүстэй сумын ерөнхий боловсролын сургууль 3,5 сая төгрөгийн,
  - Их-уул сумын сургууль 6,1 сая төгрөгийн алдааг илрүүлэн зөвлөмж хүргүүлэн ажиллалаа.
2. Байгууллагын эзэмшил газар элэгдэл тооцсон
- ✓ Сонгино сумын Хүүхдийн цэцэрлэг 53,8 сая төгрөгөөр,
  - ✓ Ургамал сумын Сургууль 3,8 сая төгрөгөөр,
  - ✓ Баянхайрхан сумын ЗДТГ 0,4 сая төгрөгөөр тус тус элэгдэл тооцон Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн тайланд нэгтгүүлсэн алдааг тус бүрийг залруулан ажиллалаа

### 2.8.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 2,206.8 сая, эцсийн үлдэгдэл 2,144.3 сая төгрөг болж, 62.5 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт №7. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/*

Нийт өр төлбөр	2,206.80	2,144.30	(62.50)
<b>БХӨТ</b>	902.40	839.90	(62.50)
<b>Өглөг</b>	<b>146.30</b>	<b>215.80</b>	69.50
Ажилчидтай холбогдсон өглөг	12.20	45.40	33.20
Бараа үйлчилгээний зардлын өглөг	126.40	162.70	36.30
Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг	7.70	7.70	-
<b>Бусад өглөг</b>	<b>736.10</b>	<b>624.10</b>	(112.00)
Байгууллагад төлөх өглөг	197.50	134.20	(63.30)
Хувь хүмүүст төлөх өглөг	1.00	12.40	11.40
Татварын өглөг /ТӨҮГ/	114.10	143.50	29.40
НДШ - ийн өглөг /ТӨҮГ/	17.70	28.70	11.00
Дансны өглөг /ТӨҮГ/	405.80	305.30	(100.50)
<b>Урьдчилж орсон орлого</b>	<b>20.00</b>	-	(20.00)
Бусад урьдчилж орсон орлого	20.00		(20.00)
<b>Урт хугацаатай өр төлбөр</b>	<b>1,304.40</b>	<b>1,304.40</b>	-
<b>Төгрөг</b>	1,304.40	1,304.40	-
Урт хугацаатай зээл	1,304.40	1,304.40	-

*Эх сурвалж: Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлан оны УХӨТ-ийн эхний үлдэгдлийн 1304,4 сая төгрөг нь “Амь-Ус трейд” ОНӨААТҮГ-ын дамжуулан зээлдүүлсэн Дэлхийн банканд төлөх олон жил болсон өглөг байна.

*Аудитын илрүүлэлт: Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын өглөгийн данстай холбоотой илэрсэн алдаа, зөрчлүүдээс дурдвал:*

- ✓ Улиастай сумын ерөнхий боловсролын Чандмань-Эрдэнэ лаборатори сургууль: Өр төлбөр данснызүсийн үлдэгдэл 15,6 сая төгрөг байгаа нь түлш халаалтын зардлын төсвийн төлөвлөлтийг алдаатай тооцоолж хийсэн, халаалт ханган нийлүүлэгч байгууллага мЗ -ийн үнээ нэмсэнтэй холбоотой байна.
- ✓ Сумдаас Эрдэнэхайрхан, Асгат, Тэс, Ургамал Алдархаан, Улиастай, Дөрвөлжин сумд 8.5-60.7 сая төгрөгийн өртэй байна

### 2.8.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 125,462.4 сая, эцсийн үлдэгдэл 134,016.8 сая төгрөг болж, 8554.4 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №8. Нийт Засгийн газрын хувь оролцоо үлдэгдэл /сая төгрөг/*

**Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>134,016.80</b>	<b>145,455.90</b>	11,439.10
<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>134,016.80</b>	<b>145,455.90</b>	11,439.10
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	56,913.00	57,432.50	519.50
Өмч: - төрийн /ТӨҮГ/	5,431.20	5,366.90	(64.30)
- хувийн /ТӨҮГ/	300.00		(300.00)
- хувьцаат			-
Халаасны хувьцаа			-
Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/	202.60	202.60	-
Эздийн өмчийн бусад хэсэг	132.90	228.80	95.90
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>36,612.80</b>	<b>47,978.70</b>	11,365.90
Өмнөх үеийн үр дүн	36,612.80	36,868.40	255.60
Тайлант үеийн үр дүн		11,110.30	11,110.30
Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс			-
<b>Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү</b>	<b>34,424.30</b>	<b>34,246.40</b>	(177.90)

*Эх сурвалж: Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Өмчийн өөрчлөлтийн тайлангийн Засгийн газрын сан данс 11.439.1 сая төгрөгөөр нэмэгдсэн дүнтэй байна.

*Аудитын илрүүлэлт: Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайланд аймгийн өрхийн эмнэлгүүдийн ӨӨТ-д гарсан 15,5 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулсан болно*

### **2.9.1 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 24 төсвийн төвлөрүүлэн захирагч, 7 төрийн /орон нутгийн/ өмчит аж ахуйн нэгж, 220 төсвийн шууд захирагч, нийт 251 нэгжийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Үүнээс 72 нэгж буюу Сум Хөгжүүлэх Сан, сумдын Соёлын төв, ОНХС-ийн үйл ажиллагаанд түүвэр аудитыг хийж, 30 төсөвт байгууллагын санхүүгийн тайланд итгэл үзүүлэн, 149 нэгж байгууллагын санхүүгийн тайлан, аймгийн ТЕЗ-ийн нэглэгсэн санхүүгийн тайлан нийт 150 нэгжид аудитын дүгнэлт өгч ажиллалаа.

Дүгнэлт өгсөн байгууллагуудаас 127 нэгж байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлтийг, 20 нэгж байгууллагын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт, 3 нэгж байгууллагын санхүүгийн тайланд “Сөрөг” санал дүгнэлтийг тус тус өгсөн байна.

*“Хязгаарлалттай” санал дүгнэлтийг Завханмандал, Сантмаргац, Цагаанхайрхан, Тэлмэн, Тэс, Баянтэс, Түдэвтэй, Дөрвөлжин, Отгон, сумдын ЗДТГазрын, Завханмандал, сумын ИТХурлын, Яруу, Шилүүстэй сумдын ЕБС-ийн, Тосонцэнгэл, Яруу, Дөлвөлжин, Отгон сумдын Хүүхдийн цэцэрлэгийн, Тосонцэнгэл “Мөнхийн алба” өрхийн эмнэлгийн, Баянхайрхан сумын Эрүүл мэндийн төвийн, аймгийн Хүүхэд гэр бүл залуучуудын төвийн Дөрвөлжин сумын “Шинэ Дөрвөлжин” ОНӨҮГ-ын санхүүгийн тайлангуудад өгсөн байна.*

*“Сөрөг” санал дүгнэлтийг Баянхайрхан, Шилүүстэй сумдын ЗДТГазар, Дөрвөлжин сумын сургуулийн санхүүгийн тайланд өгсөн байна.*

Санхүүгийн тайлангаа Төсвийн тухай хууль заасан хугацаанд аудитын байгууллагад ирүүлээгүй Асгат сумын боловсролын салбарын, Тосонцэнгэл сумын 3, 5 дугаар

**Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

цэцэрлэгийн нягтлан бодогч нарт, “Сөрөг” дүгнэлт өгөгдсөн Баянхайрхан, Шилүүстэй сумдын ЗДТГазар, Дөрвөлжин сумын сургуулийн удирдах ажилтануудад хариуцлагын арга хэмжээ авах албан шаардлагыг хүргүүллээ.

Завхан аймгийн засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар төсвийн төлөвлөлт, зарцуулалт, нягтлан бодох бүртгэл, бусад тооцоололтой холбоотой нийт 6,438.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрлээ.

Үүнээс 3,617,8 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 1,319.3 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч, 91,2 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 1,409.8 сая төгрөгийн алдааг давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлэн ажиллаа.

**Төсвийн төлөвлөлт**

Сангийн яам Аймгийн ТЕЗ-ийн 2020 онд бүрдүүлэх орлогыг 79,955.1 сая төгрөгөөр анх баталсан бөгөөд улс орны эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдал, цар тахлын хөл хориотой холбоотой улсын хэмжээнд төсөвт тодотгол хийж, төсвийн ерөнхийлөн захирагчийн бүрдүүлэх орлогыг 2,177.6 сая төгрөгөөр бууруулан 77,777.5 сая төгрөгөөр баталжээ.

Аймгийн ИТХ-ын 2019 оны 49 дугаар тогтоолоор Сангийн яамны хянасан суурь орлогыг 160.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан бөгөөд уг нэмэгдэл нь Аймгийн ИТХ-ын нэмэлт даалгавар байв.

Мөн тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын өөрийн орлогоор 197.6 сая, төсөвт байгууллагуудын өөрийн орлогоор 85.5 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Харин Аймгийн ИТХ-ын 2020 оны 61 дүгээр тогтоолоор төсөв тодотгохдоо Сангийн яамны тодотгосон дүнгээс 306.0 сая төгрөгөөр төсвийн орлогыг нэмэгдүүлэн баталжээ.

Ингэхдээ Сангийн яамны хянасан суурь орлогын бууралт 146.0 сая төгрөгийг татварын орлогын давсан хэсгээс санхүүжүүлэхээр баталжээ.

Аймгийн ИТХ-ын 2020 оны 61 дүгээр тогтоолоор 2020 оны төсвийг санхүүжүүлэх эх үүсвэрийг дор дурдсанаар тодотгон баталжээ.

		Хүснэгт-3 /сая.төг/
Д/д	Төсвийн эх үүсвэр	Мөнгөн дүн
1	Татварын болон татварын бус орлого	8,284.6
2	Аймгийн төсөвт улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	18,897.9
3	Аймгийн төсөвт улсын төсвөөс шилжүүлэх тусгай зориулалтын шилжүүлэг	45,969.0
4	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	423.6
5	ОНХС-д олгох орлогын шилжүүлэг	4,508.3
6	Төсөвт байгууллагын өөрийн орлогоос	283.2
7	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	450.0
8	2020 оны татварын давсан хэсгээс санхүүжих	365.4
ДҮН		79,182.0

**Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 76,456.7 сая төгрөг буюу 96.5 хувьтай байна.

**Тухайн жилд санхүүгийн тайлангийн аудит хийхэд анхаарах асуудал, баримтлах нэгдсэн бодлого, чиглэл:**

Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журмын 10.21,10.24-д заасны дагуу Төрийн аудитын байгууллагаас 2019 онд санхүүгийн тайлангийн аудит хийх

**Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

бодлого, чиглэлийг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2019 оны 11 дүгээр сарын 12-ны А/87 дугаар тушаалаар баталсан чиглэлийн дагуу 2020 оны санхүүгийн тайланд аудитыг хийлээ. Үүнд :

- Биет бус хөрөнгийн ашиглалт, орлого, зарлагын бүртгэл, тайлагнал зохих шаардлагад нийцэж байгаа эсэх.
- Шилэн дансны хуулийн хэрэгжилт
- Аймаг сумын хэмжээнд мөрдөж байгаа дулаан, халаалтын үнэ тариф, тусгай зөвшөөрөл эдэмшигчдтэй байгуулсан гэрээ, гэрээний хэрэгжилт
- Ковид-19 цар тахалтай холбоотой олгогдсон хандив, гарсан зардал
- Улсын секторын Нягтлан бодох бүртгэлийн программ хангамж өнөөгийн нөхцөл шаардлагад нийцэж байгаа эсэх асуудлыг судалж, үнэлэлт өгөх.
- Тайлант оны цалин, урамшуулал олголт
- Үндсэн хөрөнгийн орлого, зарлага

Дээрх чиглэлийн дагуу аудитын явцад төсвийн зарцуулалттай холбоотой зарим ажил гүйлгээг судлан үзлээ.

1. Сумдын ИТХ, ЗДТГ, ЕБС, Хүүхдийн цэцэрлэгүүдэд төсвийн хөрөнгөөр 175,2 сая төгрөгийн НББ-ийн программыг Си-Ти-Эс ХХК-аас худалдан авч нийлүүлсэн нь ашиглаж байгаа “Acolous”. “Динамик” програмуудаас хэд дахин илүү үнэтэй, уг программыг 2020 оны 5, 6 саруудад нийт үнийг бүрэн шилжүүлж авсан боловч дээрх байгууллагууд НББ-ын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1. /Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө/ гэсэн заалтыг хэрэгжүүлж бүртгэлд тусгаагүй, тайлант онд ашиглаагүй дутагдал илэрснийг аудитын явцад залруулан ажиллалаа.

*Программын ашиглалтын талаар нягтлан бодогчдоос тодруулахад уг программыг ашиглахад хүндрэлтэй, цалингийн программтай холбогдоогүй, өндөр үнэтэй, тогтмол ашиглахад өндөр хурдны интернет, компьютер шаарддаг бидний интернетийн хурд удаан компьютерын хүчин чадал муу зэргээс ашиглах боломжгүй байна гэсэн тайлбарыг өгч байна.*

2. Сумдын Хүүхдийн цэцэрлэг, зарим ЗДТГ, сургуульд компьютер, принтерыг дээрх Си-Ти-Эс ХХК-аас худалдан нийлүүлсэн нь Засгийн газрын 2020 оны 2 сарын 78 тоот, 2020 оны 3 сарын 114 тоот тогтоолуудтай нийцэхгүй байна гэж үзлээ.

*Иймд цаашид хөрөнгө бэлтгэхдээ хэрэгцээ шаардлага, зах зээлийн үнэ, хэрэглээ зэргийг судлан, хөрөнгө бэлтгэх ЗГ-ын тогтоолыг баримтлахад анхаарч ажиллах хэрэгтэй байна.*

